



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/2024

Улаанбаатар хот

“Иргэний андгай өргөх ёслол”-ын арга
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээнд дүүргийн иргэний үнэмлэх шинээр авах 16 нас хүрсэн иргэдийг 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хамруулахыг Улсын бүртгэлийн хэлтэс (М.Уранцэцэг)-т үүрэг болгосугай.

2. “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагаа зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар, иргэний үнэмлэх шинээр авах сурагчдын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 1,334,500 (Нэг сая гурван зуун гучин дөрвөн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны дүгээр сарын ны өдрийн
10 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Эх орны ирээдүйн эзэн болох 16 нас хүрсэн сурагчдын төлөөлөлд Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулсанаар тэднийг эх орон түүх соёлоороо бахархах, иргэний үүргээ биелүүлэх ухамсарт иргэн болж төлөвшихөд хувь нэмэр оруулахад оршино.

Хамрах хүрээ:

16 нас хүрч шинээр иргэний үнэмлэхээ гардан авах сурагчид оролцоно.

Зохион байгуулах газар:

Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс

Хугацаа, зохион байгуулагдах газар:

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 10.00 цагт дүүргийн ЗДТГазрын “Хурлын танхим”-д зохион байгуулагдана.


Тавигдах шаардлага:

Оролцох сурагчдын төлөөлөл ёслолын хувцастай байна. /сурагчийн форм/

Зохион байгуулах үйл ажиллагаа:

16 нас хүрсэн сурагчдад Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулан Монгол улсын “Иргэний андгай” өргөнө. Дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга зэрэг удирдлагуудтай дурсгалын зураг авахуулна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 20 ны өдрийн
13 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“ИРГЭНИЙ АНДГАЙ” ӨРГӨХ ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
3	Ном	ш	33	18000	594000
4	Бал	ш	33	2000	66000
5	Тэмдэглэлийн дэвтэр	ш	33	10000	330000
6	Дурсгалын зураг	ш	33	5000	165000
7	Тавгийн чихэр	кг	4	15000	60000
8	Ундаа	ш	40	1500	60000
9	Бензин зардал	Л	25л	2380	59500
Нийт					1334500